ДАРГА
МАО ЦЗЭДУНГИЙН
ТАВАН ЗОХИОЛ



ОРОН БҮХНИЙ ПРОЛЕТАРИ НАР НЭГДЭГТҮН!

ДАРГА
МАО ЦЗЭДУНГИЙН
ТАВАН ЗОХИОЛ




ГАДААД ХЭЛНИЙ
ХЭВЛЭЛИЙН ГАЗАР
БЭЭЖИН 1972

ХЭВЛЭЛИЙН ГАЗРААС

«Дарга Мао Цзэдунгийн таван зохиол» гэдэг энэ товхимлыг Бээжин дэх «Жэньминь чубаньшэ» хэвлэлийн газраас 1967 оны 12 дугаар сард хэвлэн гаргасан хятад эхээр орчуулав.

Бүгд Найрамдах Хятад Ард Улсад хэвлэв.



毛澤东

ГАРЧИГ

АРД ТҮМЭНД ҮЙЛЧЛЭХ НЬ 1

Н. БЕТЬЮНИЙ ДУРСГАЛД 6

ЮЙ-ГУН УУЛЫГ НҮҮЛГЭСЭН НЬ 12

НАМЫН ДОТОРХИ БУРУУ ҮЗЛҮҮДИЙГ ЗАСАЖ ЗАЛРУУЛАХ ТУХАЙ 22

Дан цэргийн үзлийн тухай 24

Хэт ардчиллын тухай 32

Намын зохион байгуулалтын зарчмыг үл ойшоогч үзлийн тухай 36

Үнэмлэхүй тэгшитгэх үзлийн тухай 39

Субъективизмийн тухай 42

Хувиа бодох үзлийн тухай 45
Тэнүүл дээрэмчийн үзэл санааны тухай 51
Путчизмийн үлдэгдлийн тухай 54
ЛИБЕРАЛИЗМЫГ ЭСЭРГҮҮЦЭХ НЬ 56

АРД ТҮМЭНД ҮЙЛЧЛЭХ НЬ

(1944 оны 9 дүгээр сарын 8)

Манай Коммунист нам ба Коммунист намаар удирдуулсан 8 дугаар замын арми, Шинэ 4 дүгээр корпус бол хувьсгалын эгнээ мөн. Манай энэ эгнээ ард түмнийг чөлөөлөхийн төлөө аль бүхнээ зориулдаг бөгөөд ард түмний эрх ашгийн төлөө тууштай ажилладаг юм. Нөхөр Чжан Сы-дэ бол манай энэ эгнээний байлдагчдын нэг билээ.

Хүн бүр үхлээс хэлтрэхгүй юм, гэхдээ үхэхийн учир утга нь өөр өөр байдаг. «Хүн бүхэн үхмүй. Үхэхэд

Тайшань уулнаас хүнд ину буй, хээрийн галууны ноолуураас хөнгөн ину буй» гэж Хятадын эртний зохиолч Сыма Цянь хэлжээ. Ард түмний эрх ашгийн төлөө үхэх нь Тайшань уулнаас ч хүнд, фашистуудын төлөө зүтгэх, ард түмнийг мөлжигчид, дарлагчдын төлөө үхэх нь хээрийн галууны ноолуураас ч хөнгөн юм. Нөхөр Чжан Сы-дэ бол ард түмний эрх ашгийн төлөө үхсэн юм, түүний үхсэн нь Тайшань уулнаас ч хүнд байна.

Бид ард түмэнд үйлчилдэг учраас дутагдалтай бол бусдын заан гаргаж шүүмжлэхээс айхгүй. Бидний дутагдлыг хэн ч заан гаргаж болно. Хэлсэн чинь зөв л юм бол бид дутагдлаа засна. Гаргасан санал чинь ард түмэнд ашигтай юм бол бид тэр ёсоор хийнэ. «Цэргийг чанаржуулж, захиргааны аппаратыг цомхотгох» гэсэн саналыг манай намын гишүүн бус зүтгэлтэн

ноён Ли Дин-мин дэвшүүлэн гаргасан юм. Тэр нь ард түмэнд тустай сайн саналыг гаргасан болохоор бид түүнийг авч хэрэгжүүлэв. Бид ард түмний эрх ашгийн төлөө зөв бүхнийг хатуу баримталж, ард түмний эрх ашгийн төлөө буруу бүхнийг засан залруулах л юм бол манай энэ эгнээ хөгжин мандах нь гарцаагүй.

Бид бол улс орныхоо өнцөг булан бүрээс ирж, хувьсгалт нийтийн зорилгын төлөө цугларсан билээ. Бид манай бүх ард түмний олонхитой хамт энэхүү зорилго өөд үргэлжлэн давших болно. Өнөөдөр бид 91 сая хүн амтай тулгуур баазуудыг удирдаж байгаа юм, гэвч энэ нь бас хангалтгүй, цаашид улам өргөжвөл бид бүх үндэстнээ чөлөөлж сая чадна. Бэрхшээл тохиолдсон үед манай нөхөд амжилтаа олж үзэх хэрэгтэй, саруул ирээдүйгээ олж үзэх хэрэгтэй, эрэлхэг зоригоо бад-

руулах хэрэгтэй. Хятадын ард түмэн гашуун зовлонд нэрвэгдэж байна; бид тэднийг аврах үүрэгтэй бөгөөд үүний төлөө хүч чармайлттайгаар тэмцэл хийх ёстой. Тэмцэл хийх юм бол амь үрэгдэх явдал тохиолддог, хүн үхэх хэрэг үргэлж гардаг. Гэвч бид ард түмний эрх ашгийг, ард түмний олонхийн гашуун зовлонг бодож санаад ард түмний төлөө үхэх нь зүйтэй хэрэг юм. Гэлээ ч гэсэн учир утгагүйгээр амь үрэгдэх явдлыг бид аль чадахаар багасгах хэрэгтэй. Манай удирдах боловсон хүчнүүд байлдагч бүхнийг халамжлах хэрэгтэй бөгөөд хувьсгалын эгнээнд байгаа бүх хүмүүс бие биеэ халамжлан хайрлаж бие биедээ тусалж байвал зохино.

Үүнээс хойш манай эгнээний аль нэгэн хүн үхсэн ч, тогооч буюу байлдагч ч болтугай, хэрэв тэр нь ашигтай ажил хийсэн л юм бол бид түү-

нийг оршуулах ёслол явуулж, гашуудлын цуглаан хийх хэрэгтэй. Энэ нь ёс журам болох ёстой. Үүнийг мөн ард олны дунд дэлгэрүүлэх хэрэгтэй. Тосгонд аль нэгэн хүн үхсэн юм бол гашуудлын цуглаан хийх хэрэгтэй. Үүгээрээ бид эмгэнэл гашуудлаа илэрхийлж, бүх ард түмний нэгдэл нягтралд тус хүргэнэ.

Н. БЕТЬЮНИЙ ДУРСГАЛД

(1939 оны 12 дугаар сарын 21)

Нөхөр Бетьюн бол Канадын Коммунист Намын гишүүн, 50 гаруй настай, Японыг эсэргүүцэх дайнд бидэнд туслахын төлөө Канадын Коммунист Нам ба АНУ-ын Коммунист Намын томилолтоор алс замын бэрхшээлийг давж Хятадад хүрч ирсэн билээ. Ноднин хавар Яньаньд хүрч, дараа нь Утайшаний районд очиж ажиллаж байгаад завшаан бусаар нас нөхөцжээ. Тэр нь гадаад хүн байтлаа аминч зорилгын хойноос өчүүхэн ч хөөцөлдөлгүйгээр Хятадын ард түмний эрх

чөлөөний үйлсийг өөрийнхөө үйлс гэж үзжээ. Энэ нь ямар зориг санаа вэ? Энэ бол интернационалч зориг санаа, коммунист зориг санаа мөн. Хятадын Коммунист Намын гишүүн нэг бүр энэхүү зориг санааг сурах хэрэгтэй. Капиталист орнуудын пролетари нар колони ба хагас колони орнуудын ард түмний эрх чөлөөний төлөө тэмцлийг дэмжиж, түүнчлэн колони ба хагас колони орнуудын пролетари нар капиталист орнуудын пролетари нарын эрх чөлөөний төлөө тэмцлийг дэмжвэл дэлхийн хувьсгал сая ялж чадна гэж ленинизм сургадаг. Нөхөр Бетьюн ленинизмийн энэхүү шугамыг практик дээр хэрэгжүүлсэн билээ. Хятадын Коммунист Намын гишүүд бид бас энэ шугамыг практик дээр хэрэгжүүлэх ёстой. Бид, капиталист бүх орнуудын пролетари нартай, Японы, Английн, АНУ-ын, Германы, Италийн ба

капиталист бусад бүх орнуудын пролетари нартай нэгдэх хэрэгтэй бөгөөд гагцхүү тэр цагт л империализмыг унагааж, манай үндэстэн ба ард түмнийг чөлөөлж, дэлхийн үндэстнүүд ба ард түмнүүдийг чөлөөлж чадна. Энэ бол манай интернационализм мөн бөгөөд үндэсний явцуу үзэл ба эх оронч явцуу үзлийн эсрэг тэмцэхэд манай зэвсэг болсон интернационализм юм.

Хувийнхаа төлөө огтхон ч боддоггүй, бусдын төлөө мятрашгүй зүтгэдэг нөхөр Бетьюний зориг санаа нь ажилдаа туйлын хариуцлагатай бөгөөд нөхдөд болон ард түмэнд туйлын халуун сэтгэлтэй байдаг явдлаар илэрч байна. Коммунист намын гишүүн бүхэн түүнээс сурах ёстой. Цөөн бус хүмүүс ажилд хариуцлагагүй хандаж хөнгөнийг эрэн хүндээс зайлж, хүнд үүргийг бусдад тохож хөнгөний нь өөртөө авдаг юм. Ямар нэг хэрэг тохиолд-

вол юуны өмнө өөрийнхөө төлөө бодож дараа нь бусдын төлөө боддог. Өчүүхэн хүч гаргаснаа үлэмжхэн гавьяагаар үзэж, бусдын олж мэдэхгүйгээс айгаад биеэ гайхуулдаг. Нөхдөд болон ард түмэнд оргилом халуун сэтгэлтэй биш, харин хүйтэн сэтгэлтэй, хайхрамжгүй, хэнэггүйгээр handдаг. Үнэндээ ийм хүмүүс бол коммунист намын гишүүн биш, наад зах нь тэднийг ёстой коммунист намын гишүүнд тооцож болохгүй. Фронтоос буцаж ирсэн хүмүүсийн дотор Бетьюний тухай ярихдаа түүнийг бишрэхгүй, түүний зориг санаанд сэтгэл хөдлөхгүй хүн нэг ч байхгүй билээ. Эмч Бетьюнээр эмнүүлсэн буюу түүний ажиллахыг нүдээрээ үзсэн Шаньси — Цахар — Хэбэйн хязгаар районы цэрэг ардын дотор сэтгэл хөдлөхгүй хүн гэж байхгүй. Коммунист намын гишүүн нэг бүр нөхөр Бетьюний энэхүү ёстой

коммунист хүний зориг санааг заавал сурах хэрэгтэй.

Нөхөр Бетьюн бол эмч мөн. Тэр нь эмчилгээний ажлыг өөрийн мэргэжил болгож мэргэшлийнхээ хэмжээг цуцалтгүй дээшлүүлдэг байсан юм. 8 дугаар замын армийн нийт эмнэлгийн үйлчилгээнд тэр нь эмчлэх мэргэшлээрээ оройлдог байлаа. Энэ нь өөрийн мэргэжлиййг хөнгөмсгөөр солих зантай, мэргэжил техникийн ажлыг ялимгүй, ирээдүйн төлөвгүй гэж голж үздэг хүмүүст онц сайн сургамж ч болно.

Би нөхөр Бетьюнтэй нэг л удаа уулзжээ. Түүнээс хойш тэр надад олон захидал ирүүлэв. Гэтэл завгүй учраас би хариу захидал ганцхан явуулсан, түүний олж авсан эсэхийг ч мэдэхгүй. Түүний нас барсан явдалд миний бие гүнээ эмгэнэж байна. Одоо бүгдээрээ Бетьюнийг дурсгаж байна, энэ нь түүний зориг санаа бидэнд хичнээн гүн

сэтгэгдэл төрүүлснийг харуулав. Амины ашгийг өчүүхэн ч боддоггүй түүний зориг санааг бид бүгдээрээ сурах хэрэгтэй. Ийм зориг санаатай хүн бүр ард түмэнд маш их тустай хүн болж болно. Хүн бол их чадвартай бага чадвартай гэж байдаг, гэвч энэхүү зориг санаатай л байвал эрхэм дээд хүн, ёстой хүн, зан суртахуунтай хүн, дорд сонирхлоос ангижирсан хүн, ард түмэнд тустай хүн болно.

ЮЙ-ГУН УУЛЫГ НҮҮЛГЭСЭН НЬ

(1945 оны 6 дугаар сарын 11)

Манай их хурал тун амжилттай боллоо. Бид гурван ажил хийлээ, үүнд: нэгдүгээрт, намын шугамыг тогтоосон, энэ нь олон түмнийг зоригтойгоор дайчлан, ард түмний хүчийг өсгөн нэмэгдүүлж, манай намын удирдлагын дор Японы түрэмгийлэгчдийг бут цохиж, бүх ард түмнийг чөлөөлөн, шинэ ардчилсан Хятадыг байгуулах явдал болно. Хоёрдугаарт, намын шинэ дүрмийг батлав. Гуравдугаарт, намын удирдах байгууллага болох Төв Хороог сонголоо.

Үүнээс хойшхи манай зорилт бол намын шугамыг биелүүлэхэд нийт намыг удирдах явдал юм. Бид ялалтын их хурал, нягтралын их хурал хийж өнгөрлөө. Тус их хурал дээр тавьсан гурван илтгэлийн талаар төлөөлөгчид үнэтэй цэнтэй саналууд илэрхийлэв. Нилээд нөхөд өөрийн шүүмжлэл хийж, нягтрах зорилгын үүднээс өөрийн шүүмжлэлийг хийснээр нягтралд хүрсэн байна. Энэ их хурал бол нэгдэл нягтралын үлгэр жишээ, өөрийн шүүмжлэлийн үлгэр жишээ, түүнчлэн намын дотоод ардчиллын үлгэр жишээ мөн.

Их хурлын дараа олон нөхөд тус тусынхаа ажилладаг газарт буцаж, дайн байлдааны районууд руу явахаар байна. Та нөхөд ажилладаг газартаа харьж очоод, их хурлын шугамын тухай сурталчлах хэрэгтэй бөгөөд намын бүх гишүүдээр дамжуулан, ард

түмэнд тайлбарлах өргөн далайцтай ажил зохион явуулбал зохино.

Бид их хурлын шугамыг сурталчилснаар нийт нам, бүх ард түмнийг хувьсгал зайлшгүй ялна гэдэгт итгэх итгэлтэй болгох хэрэгтэй. Юуны урьд манлайлагч отрядыг ухамсарлуулан, түүнийг эрс зоригоо гаргаж, амь үрэгдэхээс айхгүй, бэрхшээл бүхнийг давж, ялалтын төлөө тэмцэхэд хүргэх хэрэгтэй. Гэвч үүгээрээ зогсох ёсгүй, бас нийт орны өргөн ард олныг ухамсарлуулан, тэднийг сайн дураараа бидэнтэй хамт ялалтын төлөө тэмцэхэд хүргэх ёстой. Хятад бол Хятадын ард түмнийх юм, харин харгис бүлгийнх биш гэдэгт итгэх итгэлийг бүх ард түмэнд төрүүлэх нь чухал. Хятадын эртний үед «Юй-гун уулыг нүүлгэсэн нь» гэдэг ёгт үлгэр байжээ. Тэр үлгэрт хэлсэн нь: Эрт урьд цагт Хойт Хятадад Хойт уулын Юй-гун гэдэг өвгөн

сууж байсан гэнэ. Түүний гэрийн өмнө байдаг Тайханшань ба Ванъушань гэдэг хоёр их уул гарах замы нь хаасан байжээ. Юй-гун хөвгүүдээ дагуулан энэ хоёр их уулыг хүрз зээтүүгээр малтаж хаяхаар зориг шийджээ. Чжи-соу гэдэг нөгөө өвгөн үүнийг үзээд инээд хүрч, «Ингэж байгаа чинь даанч тэнэг байна даа, та аав хүү хэдүүлээ ийм хоёр их уулыг малтаж нураах гэсэн чинь огт боломжгүй хэрэг шүү» гэв. Түүнд Юй-гун хариулахад: «Намайг үхвэл хүү бий, хүү үхвэл ач бий, энэ мэтээр эцэс төгсгөлгүй үе улиран залгамжилдаг билээ. Хэдийгээр энэ хоёр уул их өндөр боловч дахиад улам өндөр болж чадахгүй юм. Хэдий малтвал төдий хорогдох болохоор яагаад малтан нурааж чадахгүй вэ?» гэжээ. Чжи-соугийн буруу үзлийг няцаагаад Юй-гун өчүүхэн ч эргэлзээ-

гүй, өдөр бүр уулыг зогсолтгүй малтаж гэнэ. Энэ явдалд нь хурмаст тэнгэр сэтгэл уярч хоёр сахиулсныг ертөнц дээр буулгаад тэр хоёр уулыг үүрүүлэн зайлуулав гэнэ. Одоо Хятадын ард түмний бие дээр бас империализм, феодализм гэдэг хоёр их уул дарж байна. Хятадын Коммунист Нам энэ хоёр уулыг малтан нураахаар аль хэдийн зориг шийдсэн билээ. Бид заавал шургуу чармайж тасралтгүй ажиллах ёстой, бид бас хурмаст тэнгэрийн сэтгэлийг уяруулж болно. Энэхүү хурмаст тэнгэр гэдэг нь өөр хүн биш, харин бүх Хятадын ард олон мөн. Бүх ард олон босоцгоож, бидэнтэй хамт малтвал энэ хоёр уулыг нурааж чадахгүй хэрэг юу байх вэ?

АНУ-д буцах гэж байгаа хоёр америк хүнтэй өчигдөр ярилцахдаа, Америкийн засгийн газраас манай үйл

хэргийг эвдэхээр эрмэлзэж байна, үүнийг бид зөвшөөрөхгүй юм гэж би мэдэгдсэн. Чан Кай-шийг дэмжин Коммунист намыг эсэргүүцэхэд чиглэгдсэн Америкийн засгийн газрын бодлогыг бид эсэргүүцнэ. Гэтэл бид нэгдүгээрт, Америкийн ард түмнийг тэдний засгийн газраас ялгаж үзэх, хоёрдугаарт, Америкийн засгийн газрын доторхи улс төрийн бодлого тогтоогч хүмүүсийг доор нь ажилладаг энгийн ажилтнуудаас ялгаж үзэх хэрэгтэй. Би тэр хоёр америк хүнд: «Манай чөлөөлөгдсөн районуудад та нарын орохыг бид хориглоно, учир нь танай бодлого бол Чан Кай-шийг дэмжин Коммунист намыг эсэргүүцэхэд чиглэгдсэн болохоор бид та нарыг итгэхгүй байна гэдгийг танай засгийн газрын доторхи улс төрийн бодлого тогтоогч хүмүүст хэлээрэй. Хэрэв та нар Японыг эсэргүүцэхээр манай чө-

чөлөөлөгдсөн районуудад ирэх юм бол болно, гэхдээ үүний тухай хэлэлцэн тохиролцох хэрэгтэй. Та нар энд тэнд сэмхнээр дураараа явах юм бол бид зөвшөөрөхгүй. Хятадын Коммунист Намтай хамтран ажиллахаас татгалзаж байгаагаа Хэрли нэгэнт илээр мэдэгдсэн билээ. Тэгсэн мөртлөө манай чөлөөлөгдсөн районуудад ирж дураараа явахын хэрэг юу байх вэ?» гэж хэлсэн юм.

Чан Кай-шийг дэмжин Коммунист намыг эсэргүүцэхэд чиглэгдсэн Америкийн засгийн газрын бодлого нь Америкийн харгисчуудын улайран улангассаныг харуулсан байна. Гэвч Хятадын ард түмний ялалтад хүрэхэд саад учруулах гэсэн Хятадын ба гадаадын харгисчуудын аливаа оролдлого нь зайлшгүй балран унана. Одоо дэлхийн байдлын ерөнхий

урсгалд ардчилал нь гол урсгал болж, харин ардчиллын эсрэг харгислал нь зөвхөн сөрөг урсгал төдий юм. Одоо үндэсний тусгаар тогтнол болон ардын ардчиллын гол урсгалыг дарах гэж харгис сөрөг урсгал оролдоод л байвч тэр нь хэзээ ч гол урсгал болон хувирч чадахгүй юм. Одоо үед И. В. Сталины аль хэзээний хэлсэн хуучин ертөнц дэх гурван их зөрчил мөн ч оршсоор байгаа юм. Үүнд: нэгдэх нь империалист орнууд дахь пролетари хөрөнгөтөн хоёр ангийн хоорондын зөрчил, хоёрдохь нь империалист орнуудын өөр хоорондын зөрчил, гуравдахь нь колони, хагас колони орнууд ба империалист эзэн орнуудын хоорондын зөрчил болно. Энэ гурван зөрчил урьдын адил оршиж байгаагаар барахгүй, өөрийн хөгжлийн дунд улам бүр хурцдаж, улам бүр өргөж-

жээ. Зөвлөлтийн эсрэг, коммунист намын эсрэг, ардчиллын эсрэг сөрөг урсгал байгаа ч гэсэн дээр дурдсан зөрчлүүдийн орших ба хөгжихийн улмаас энэхүү харгис сөрөг урсгалын давагдах өдөр гарцаагүй ирнэ.

Одоо Хятадад хоёр их хурал хуралдаж байна. Энэ нь гоминьдангийн VI их хурал ба Коммунист намын VII их хурал болно. Энэ хоёр их хурал тэс ондоо зорилготой юм: нэг нь Коммунист нам болон Хятадын ардчилсан хүчнүүдийг устгаж, Хятадыг харанхуй байдалд оруулах гэж байна; нөгөө нь Японы империализм болон түүний уяаны нохой болох Хятадын феодалын хүчнүүдийг унагааж, шинэ ардчилсан Хятадыг бүтээн байгуулан, Хятадыг саруул байдалд оруулах гэж байна. Энэ хоёр шугам харилцан тэмцэлдэж байгаа юм. Хятадын Коммунист Намын удирдлагаар Хятадын

ард түмэн ХКН-ын VII их хурлын шугамыг удирдлага болгон бүрэн төгс ялалт хийнэ, харин гоминьдангийн хувьсгалын эсэргүү шугам нь зайлшгүй ялагдана гэдэгт бид бат итгэж байна.

НАМЫН ДОТОРХИ БУРУУ ҮЗЛҮҮДИЙГ ЗАСАЖ ЗАЛРУУЛАХ ТУХАЙ

(1929 оны 12 дугаар сар)

Улаан армийн 4 дүгээр корпусын намын байгууллагуудад пролетарийн бус янз бүрийн үзлүүд оршиж байгаа бөгөөд энэ нь намын зөв шугамыг хэрэгжүүлэхэд туйлын их саад тотгор болж байна. Хэрэв эдгээр үзлүүдийг туйлбартай засан залруулахгүй бол Улаан армийн 4 дүгээр корпусын өмнө Хятадын аугаа их хувьсгалт тэмцлийн тавьсан зорилтуудыг дааж чадахгүй нь дамжиггүй. 4 дүгээр

корпусын намын байгууллагуудад байгаа янз бүрийн зөв бус үзлүүдийн уг сурвалж нь намын байгууллагын суурийн дийлэнх хэсэг бол тариачдаас болон бусад жижиг хөрөнгөтний гаралтай хүмүүсээс бүрэлдсэн явдалд орших нь ярианггүй; гэвч намын удирдах байгууллагуудаас эдгээр зөв бус үзлүүдийн эсрэг санал нэгтэй, эрс шийдвэртэй тэмцлийг гүйцэд явуулаагүй, намын гишүүдэд зөв шугамын тухай хүмүүжлийг хангалттай олгосонгүй явдал нь мөн ч эдгээр зөв бус үзлүүдийн оршин хөгжихийн чухал шалтгаан болно. Намын бага хурал Төв Хорооны 9 дүгээр сард ирүүлсэн захидлын утга санааг үндэслэж, 4 дүгээр корпусын намын байгууллагуудын доторхи пролетарийн бус янз бүрийн үзлүүдийн илрэл, уг сурвалж болоод тэдгээрийг засан залруулах аргыг заагаад, тэд-

гээрийг бүрмөсөн цэвэрлэн арилгахыг нөхдөд уриалж байна.

ДАН ЦЭРГИЙН ҮЗЛИЙН ТУХАЙ

Дан цэргийн үзэл Улаан армийн хэсэг нөхдийн дунд ихэд дэлгэрч байна. Түүний илрэл нь гэвэл:

1. Цэргийн хэрэг улс төр хоёрыг эсрэг тэсрэг болгон үзээд, цэргийн хэрэг зөвхөн улс төрийн зорилтуудыг биелүүлэх багаж зэвсгийн нэг төдий болохыг хүлээн зөвшөөрөхгүй байна. Тэр ч байтугай, «цэргийн хэрэг сайн бол улс төр аяндаа сайн болно, цэргийн хэрэг муу бол улс төр ч аяндаа сайн болж чадахгүй» гэж хэлсэн хүн ч буй, тэд бүр цаашлаад цэргийн хэргээр улс төрийг удирдуулна гэж үзэх боллоо.

2. Улаан армийн зорилт бол цагаан армийнхтай бараг адилхан, зөвхөн байлдаан хийхэд оршиж байгаа төдий юм гэж тэд үздэг. Хятадын Улаан арми бол хувьсгалын улс төрийн зорилтуудыг биелүүлэх зэвсэгт бүлэг мөн гэдгийг тэд мэдэхгүй байна. Ялангуяа одоо үед, Улаан арми зөвхөн байлдаан хийх төдий огт биш бөгөөд тэр нь байлдаан хийж дайсны цэргийн хүчийг устгахаас гадна, олон түмний дунд суртал нэвтрүүлэг хийх, олон түмнийг зохион байгуулах, олон түмнийг зэвсэглэх, олон түмэнд хувьсгалт засгийг тогтоохад, цаашилбал Коммунист намын байгууллагуудыг байгуулахад нь туслах зэрэг чухал зорилтуудыг хариуцах үүрэгтэй юм. Улаан арми бол гагцхүү байлдахын төлөө байлддаг биш, харин олон түмний дунд суртал нэвтрүүлэг хийх, олон түмнийг зохион

байгуулах, олон түмнийг зэвсэглэх, олон түмэнд хувьсгалт засгийг тогтоохол нь туслахын төлөө л байлддаг; эдгээр зорилгоос хөндийрөн тасарвал байлдахын учир утгаа алдаж, Улаан армийн орших учир утгаа ч алдах юм.

3. Ийм учраас зохион байгуулалтын талаар Улаан армийн дотор улс төрийн ажил эрхлэх байгууллагыг цэргийн ажил эрхлэх байгууллагад захирагдуулж, «армийн гаднахь хэргийг штаб эрхлэх» гэсэн лоозонг дэвшүүлэн гаргажээ. Ийм үзэл санаа цаашлан хөгжвөл олон түмнээс хөндийрөн тасрах, засгийн байгууллагуудыг армийн хяналтанд оруулах, пролетарийн удирдлагаас ангижрахад хүрэх аюултай бөгөөд гоминьдангийн армитай адил цэргийн эрхтний үзлийн замаар явахад хүрэх аюултай юм.

4. Үүний хамт суртал нэвтрүүлгийн ажлын талаар сурталчлах бригадын чухлыг хайхрахгүй байна. Олон түмнийг зохион байгуулах талаар арми дахь цэргүүдийн хороод ба орон нутгийн ажилчин тариачин түмнийг зохион байгуулахыг ойшоохгүй байна. Үүний уршгаар суртал нэвтрүүлгийн ба зохион байгуулалтын ажил цөм хасагдах байдалд оров.

5. Байлдаанд ялсан бол ихэрхэн бардамнаж, ялагдсан бол идэвхгүй болдог.

6. Байгууллага нэгжийн явцуу үзэл, өөрөөр хэлбэл ямар ч нөхцөл байдалд 4 дүгээр корпусынхоо төлөө л санаа тавихыг мэддэгээс биш, харин орон нутгийн олон түмнийг зэвсэглэх нь Улаан армийн чухал зорилтуудын нэг мөн гэдгийг мэдэхгүй байдаг. Энэ бол өргөжсөн жижиг бүлэглэлийн үзэл юм.

7. Цөөн тооны нөхөд 4 дүгээр корпусын хэсэг талын байдалд хязгаарлагдаад 4 дүгээр корпусоос өөр бусад хувьсгалт хүчин байхгүй гэж бодож байна. Иймучраас хүчээ хадгалах, байлдах ажиллагаанаас зайлах гэсэн хүсэл бодол их сүрхий оршиж байна. Энэ бол оппортунизмын үлдэгдэл юм.

8. Субъектив, объектив нөхцөл байдлыг үл харгалзан, хувьсгалт түргэдүү зан гаргаж, олон түмний дунд жижиг, нягт нямбай ажлыг шургуу хийхийг хүсэхгүй, зөвхөн том ажил хийхийг эрмэлзэн, хоосон мөрөөдлөөр дүүрэн байдаг. Энэ бол путчизмийн үлдэгдэл юм.

Дан цэргийн үзлийн уг сурвалж нь гэвэл:

1. Улс төрийн хэмжээ нь дор. Иймээс армийн доторхи улс төрийн удирдлагын ролийг ойлгохгүй, Улаан

арми цагаан арми хоёрын хооронд үндсэн ялгаатай байдгийг ойлгохгүй.

2. Хөлсний цэргийн үзэл санаа. Байлдаан хийх болгонд олзлогдогсод нь их олон бөгөөд эдгээр этгээд Улаан армид элсэн орохдоо хөлсний цэргийн үзэл санааг үлэмж их авчирсан тул доод шатнуудад дан цэргийн үзлийн үүсэх үндэс бий болсон юм.

3. Дээр дурдсан хоёр шалтгаантай байгаагаас болж гуравдугаар шалтгаан гарчээ. Энэ нь цэргийн хүчинд хэт итгэж ард олны хүчинд үл итгэх явдал болно.

4. Намаас цэргийн ажлыг идэвхтэй анхаарч хэлэлцсэнгүй нь хэсэг нөхдийн дунд дан цэргийн үзлийн үүссэний бас нэг шалтгаан болно.

Засаж залруулах арга нь гэвэл:

1. Хүмүүжүүлэх ажлаар намын дотоодын улс төрийн хэмжээг дээшлүүлэн, улмаар дан цэргийн үзлийн

онолын үндсийг арилгаж, Улаан арми цагаан арми хоёрын хооронд үндсэн ялгаатай байгааг тодорхой таниулна. Үүний зэрэгцээгээр оппортунизм ба путчизмийн үлдэгдлийг устгаж, 4 дүгээр корпус дахь байгууллага нэгжийн явцуу үзлийг эцэс болгох хэрэгтэй.

2. Дарга ба байлдагч нарын улс төрийн бэлтгэлийг, ялангуяа олзлогдсон хүмүүсийн дунд зохиох хүмүүжлийн ажлыг эрчимтэй болгоно. Үүний хамт тэмцлийн туршлагатай ажилчин тариачдыг аль болохоор шилэн томилж Улаан армид оролцуулах ажлыг орон нутгийн засгийн байгууллагуудаар хийлгэж, улмаар зохион байгуулалтын талаар дан цэргийн үзлийн үндсийг сулруулж, цаашид арилгана.

3. Улаан армийн намын байгууллагуудад, мөн түүний дарга ба байлдагчдад нөлөө үзүүлэхийн тул

орон нутгийн намын байгууллагуудаас Улаан армийн намын байгууллагуудыг шүүмжлэх ба олон түмний засгийн байгууллагуудаас Улаан армийг шүүмжлэх шүүмжлэлийг өрнүүлнэ.

4. Намаас цэргийн ажлыг идэвхтэй анхаарч хэлэлцэх хэрэгтэй. Энэ бүх ажлын тухай намын байгууллагууд хэлэлцэж шийдвэр гаргасны дараа тэдгээр ажлыг олон түмнээр гүйцэтгүүлнэ.

5. Улаан армийн хууль дүрмийг боловсруулж, Улаан армийн зорилт, цэргийн ажлын систем ба улс төрийн ажлын системийн хоорондохь харилцаа, Улаан арми ба ард олны хоорондохь харилцаа, цэргүүдийн хороодын эрх мэдэл болон эдгээр хороодоос цэрэг, улс төрийн байгууллагуудтай харилцах харилцааг тодорхой тогтооно.

ХЭТ АРДЧИЛЛЫН ТУХАЙ

Улаан армийн 4 дүгээр корпус Төв Хорооны зааврыг хүлээн авч гүйцэтгэх болсны дараа хэт ардчиллын үзэгдэл нь нилээд багасав. Жишээлбэл намын шийдвэр урьдынхаас зүгээр хэрэгжиж чадах болсон; «доороос дээр хүртэлх ардчилсан төвлөн удирдах ёс», «эхлээд доод шатнуудаар хэлэлцүүлж, дараа нь дээд шатнуудаар шийдвэр гаргуулах» гэгч зэргийг Улаан армийн дотор биелүүлэх тухай буруу шаардлагыг дахин дэвшүүлэх гэсэн хүн ч үгүй болжээ. Гэвч үнэн хэрэг дээрээ, ингэж багассан явдал нь түр зуурын, өнгөц үзэгдэл төдий болохоос биш, харин хэт ардчиллын үзэл санаа арилчихсан хэрэг биш юм. Өөрөөр хэлбэл хэт ардчиллын үндэс олон нөхдийн үзэл санааны гүнд хэвээрээ байсаар байна. Жишээлбэл

намын шийдвэрийг биелүүлэхэд элдвээр дургүйцэж байгаа нь үүний нотолгоо мөн.

Засаж залруулах арга нь гэвэл:

1. Онолын талаар хэт ардчиллын үндсийг арилгана. Намын байгууллагуудыг хохируулж, тэр ч байтугай бүрэн эвдэж, намын дайчин чадлыг сулруулж, тэр ч байтугай бүрэн сүйтгэж, намыг тэмцлийн үүргийг дааж чадахгүй байдалд оруулан, үүний улмаас хувьсгалыг ялагдалд хүргэх явдалд хэт ардчиллын аюул оршиж байна гэдгийг юуны өмнө заах гаргах хэрэгтэй. Цааш нь хэт ардчиллын уг сурвалж нь жижиг хөрөнгөтний сахилга батгүй, салан задгай байдалд оршихыг зааж гаргах хэрэгтэй. Энэхүү сахилга батгүй, салан задгай байдал намын дотор нэвтрэн орохлоор улс төрийн болон зохион

байгуулалтын талаархи хэт ардчиллын үзэл санаа болсон байна. Иймэрхүү үзэл санаа нь пролетарийн тэмцлийн зорилттой огт нийцэхгүй юм.

2. Зохион байгуулалтын талаар, төвлөн удирдах ёсоор чиглүүлэгдсэн ардчилсан амьдралын зарчмыг хатуу баримтална. Түүнийг биелүүлэх чиг шугам нь гэвэл:

1) Удирдах төвийг бий болгохын тул намын удирдах байгууллага ажилдаа жолоодлогын зөв чиг шугамыг баримталж, ажил хэрэг тохиолдвол шийдвэрлэх арга хэмжээг гаргах хэрэгтэй.

2) Дээд шатны байгууллага нь доод шатны байгууллагынхаа байдал ба олон түмний аж амьдралын байдалтай тодорхой танилцах хэрэгтэй бөгөөд түүгээр зөв жолоодлогын объектив үндэс суурь болгоно.

3) Намын бүх шатны байгууллагууд асуудлыг хөнгөн хуумгайгаар шийдвэрлэж болохгүй. Шийдвэр гаргасны дараахан түүнийг хэлбэрэлтгүй хэрэгжүүлэх нь чухал.

4) Дээд шатны байгууллагын чухал шиг шийдвэр болгоныг доод шатны байгууллага ба намын гишүүдэд түргэн уламжлан танилцуулах нь чухал. Түүний арга нь гэвэл идэвхтнүүдийн хурал буюу намын үүрийн хурал, цаашилбал цувааны намын гишүүдийн хурлыг (бололцоотой байдалд) хийлгэж, илтгэл тавихаар хуралд хүнийг илгээнэ.

5) Намын дээд шатны байгууллагын зааврын утга санааг бүрэн ойлгож, түүнийг биелүүлэх аргуудыг тогтоохын тулд намын доод шатны байгууллага ба намын гишүүд уг зааврыг нарийн хэлэлцэх хэрэгтэй.

НАМЫН ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ЗАРЧМЫГ ҮЛ ОЙШООГЧ ҮЗЛИЙН ТУХАЙ

4 дүгээр корпусын намын байгууллагуудын дотор намын зохион байгуулалтын зарчмыг үл ойшоогч үзэл оршиж байна. Түүний илрэл нь гэвэл:

А. Цөөнх нь олонхидоо захирагдахгүй байдаг. Жишээлбэл цөөнх хүмүүсийн санал хэрэгсэгдсэнгүй бол тэд намын шийдвэрийг үнэнчээр гүйцэтгэдэггүй болдог.

Засаж залруулах арга нь гэвэл:

1. Хурал хийхдээ оролцогсдод саналаа хэлэх бүрэн бололцоог олговол зохино. Маргаантай асуудал байвал зөв буруугий нь тодорхой болгох ёстойгоос биш, эвлэрэлтэй, хааш яаш хандах ёсгүй. Тодорхой дүгнэлтийг гаргахын тулд асуудлыг нэг удаа хэлэлцээд шийдвэрлэж чадахгүй бол

(ажлыг саатуулахгүйн нөхцөл байдалд) дахиад хэлэлцэж болно.

2. Цөөнх нь олонхидоо захирагдах нь намын сахилга батын шаардлагуудын нэг болно. Цөөнх хүмүүс, өөрсдийн санал хэрэгсэгдсэнгүй үед олонхийнхоо баталсан шийдвэрийг дэмжих үүрэгтэй. Чухал хэрэгтэй байвал дараа удаагийн хурал дээр асуудлыг дахин хэлэлцүүлэхээр тавьж болохоос биш, баталсан тэр шийдвэрийг зөрчих ямар ч үйл ажиллагааг үйлдэж болохгүй юм.

Б. Намын зохион байгуулалтын зарчмыг үл ойшоогч шүүмжлэл:

1. Намын дотоод шүүмжлэл бол намын байгууллагыг бататгах, намын дайчин чадлыг нэмэгдүүлэхэд чиглэсэн зэвсэг юм. Гэтэл Улаан армийн намын байгууллагын доторхи шүүмжлэл нь заримдаа тийм биш, харин зарим нэг хүнийг дайрах явдал бол-

сон байна. Түүний уршгаар зарим нэг хүнийг төдийгүй, намын байгууллагыг ч хохируулсан байна. Энэ бол хувиа бодох жижиг хөрөнгөтний үзлийн илрэл юм. Үүнийг засаж залруулах арга нь гэвэл, шүүмжлэлийн зорилго бол намын дайчин чадлыг нэмэгдүүлж, улмаар ангийн тэмцлийг ялалтад хүргэхэд оршиж байна, харин шүүмжлэлийг зарим нэг хүнийг дайрах зэвсэг болгон ашиглах ёсгүй гэдгийг намын гишүүдэд ойлгуулах явдал болно.

2. Намын олон гишүүн намын дотор биш, харин түүний гадуур шүүмжлэлийг хийдэг. Энэ нь намын жирийн гишүүд намын байгууллагын (хурал гэх мэтийн) чухлыг ойлгоогүй бөгөөд байгууллагын дотор шүүмжлэл хийх, түүний гадуур шүүмжлэл хийх хоёрын хооронд ямар ч ялгаагүй гэж үздэгээс болсон юм. Засаж залруу-

лах арга нь намын байгууллагын чухлыг ойлгож, намын хороонд буюу зарим нөхдөд шүүмжлэл хийе гэвэл намын хурал дээр хийдэг болгохоор намын гишүүдийг хүмүүжүүлэх явдал болно.

ҮНЭМЛЭХҮЙ ТЭГШИТГЭХ ҮЗЛИЙН ТУХАЙ

Улаан армийн дотор үнэмлэхүй тэгшитгэх үзэл нэг үед их дэлгэрсэн билээ. Жишээлбэл шархадсан байлдагчдад хувийн зардлыг олгоход хөнгөн, хүнд шархдагсад гэж ялгахыг эсэргүүцэн, тэгш олгохыг шаарддаг. Дарга нарыг мориор явдгийг ажилд хэрэгтэйгээс болсон гэж үзэхгүй, харин эрх тэгш бус байдал гэж үздэг. Эд хэрэглэлийг хуваахад эрс тэгш олгохыг шаардаад, онцгой байдалтайд

нь арай илүү олгоход дургүй байдаг. Будаа үүрэхэд насанд хүрсэн буюу хүрээгүй, биеийн чийрэг буюу сул байхы нь ялгалгүйгээр адилхан үүрүүлэхийг шаарддаг. Байр байшинг яг адилаар хуваахыг шаардаж, хэрэв штабыг арай том байшинд байрлуулбал хараах явдал ч гарна. Алба даалгахад хүн бүхэнд адилхан оногдуулахыг шаардаж, арай илүү хийлгэвэл хүлээхгүй байдаг. Тэр ч байтугай шархадсан хоёр байлдагчийн дунд нэг л дамнууртай байхад хоёрын аль нэгийг дамнуулснаас хоёрыг үлдээвэл дээр гэж үздэг. Энэ бүгд нь Улаан армийн дарга ба байлдагчдын дунд үнэмлэхүй тэгшитгэх үзэл бас л их ноцтой оршиж байгааг гэрчилж байна.

Үнэмлэхүй тэгшитгэх үзлийн уг сурвалж нь улс төрийн талаархи хэт ардчиллынхтай адил, гар үйлдвэрийн

ба жижиг тариачны аж ахуйгаас гарсан бөгөөд ялгаагий нь гэвэл нэг нь улс төрийн амьдралын талаар, нөгөө нь материаллаг аж байдлын талаар илэрдэг төдий л юм.

Засаж залруулах арга нь гэвэл: капитализм устгагдаагүй үед үнэмлэхүй тэгшитгэх үзэл бол гагцхүү тариачин ба бусад жижиг хөрөнгөтнүүдийн хоосон мөрөөдөл төдий юм гэдгийг заагаад, социализмын үед ч гэсэн «хүн бүр чадлынхаа хирээр, хүн бүрд хөдөлмөрлөснийх нь хирээр» гэдэг зарчим ба ажлын шаардлага ёсоор материал хэрэглэгдэхүүнийг хуваах хэрэгтэйгээс биш, үнэмлэхүй тэгшитгэх явдал гэгч нь огтхон ч байхгүй гэдгийг тэмдэглэх нь чухал. Улаан армийнханд материал хэрэглэгдэхүүнийг хувааж өгөхөд их төлөв тэгш байх ёстой. Жишээлбэл дарга ба байлдагчдад цалин хүнсийг

тэгшхэнээр олгоно. Учир нь үүнийг тэмцлийн одоогийн нөхцөл байдал шаардаж байна. Гэтэл үнэмлэхүй тэгшитгэх үзлийн ямар ч учир ёсгүй шаардлагыг эсэргүүцвэл зохино. Яагаад гэвэл энэ нь тэмцлийн шаардлага биш, харин тэмцэлд саад тотгор болно.

СУБЪЕКТИВИЗМИЙН ТУХАЙ

Намын зарим гишүүдийн дунд субъективизм сүрхий оршиж байгаа бөгөөд энэ нь улс төрийн байдлыг задлан судалж ажлыг удирдан явуулахад нь их саад болж байна. Субъективист ёсоор улс төрийн байдлыг задлан судалж ажлыг удирдан явуулсны уршгаар эсхүл оппортунизмд, эсхүл путчизмд хүрэх нь зайлшгүй юм. Намын дотор субъек-

тивист шүүмжлэл хийх, ул үндэсгүй чалчаа үг хэлэх, харилцан сэжиглэх явдал нь олонхидоо зарчимгүй хэрүүл маргаан үүсгэж, намын байгууллагыг эвдэхэд хүргэдэг юм.

Намын дотоод шүүмжлэлийн тухай асуудлын талаар дурдмаар байгаа бас нэг зүйл гэвэл зарим нөхөд шүүмжлэл хийхдээ жижиг зүйлийг анхаарахаас биш, гол зүйлийг анхаарахгүй байна. Шүүмжлэлийн гол зорилт нь улс төр, зохион байгуулалтын талаархи алдааг заан гаргахад оршино гэдгийг тэд ойлгохгүй байна. Хувийн дутагдлын тухай гэвэл хэрэв тэр нь улс төр, зохион байгуулалтын алдаатай холбогдолгүй бол нөхдийгөө хэрхэн яахаа мэдэхгүй байдалд хүргэхгүйн тул түүнийг хэтэрхий зэмлэх хэрэггүй. Иймэрхүү шүүмжлэл өрнөн хөгжвөл намын гишүүдийн анхаарал нь дан ганц жижиг дутагдалд төвлө-

рөн, хүмүүс жижиг сажиг юмнаас хэрсүүлж, намын улс төрийн зорилтыг мартан орхиход хүрнэ. Энэ бол их аюултай хэрэг юм.

Засаж залруулах арга нь гэвэл: голдуу намын гишүүдийн үзэл санаа ба намын дотоод амьдралыг улс төрийн ба шинжлэх ухааны чиглэлтэй болгохоор намын гишүүдийг хүмүүжүүлэх явдал болно. Энэ зорилгод хүрье гэвэл: 1) марксист-ленинист аргаар улс төрийн байдлыг задлан судалж ангиудын хүчнүүдийг үнэлж, улмаар субъективист ёсоор задлан судалж үнэлэхээс татгалздаг болгохоор намын гишүүдийг хүмүүжүүлнэ; 2) нийгэм-эдийн засгийн тухай судалгаа шинжилгээ хийх ба үүний үндсэн дээр тэмцлийн тактик, ажлын арга тогтоох явдалд намын гишүүдийн анхаарлыг төвлөрүүлнэ; бодит байдлыг судлан байцаахаас хөндийрвөл

хий хоосон бодол ба путчизмийн намагт зайлшгүй хальтран орно гэдгийг нөхдөд ойлгуулна; 3) намын дотор шүүмжлэл явуулахад субъектив ёсоор, дур зоригоор хийх ба шүүмжлэлийг бүдүүлэг болгохоос сэргийлэн болгоомжилж, үг хэлэхдээ үндэс баримттай байж, шүүмжлэлийг улс төрийн зорилгын үүднээс хийх хэрэгтэй.

ХУВИА БОДОХ ҮЗЛИЙН ТУХАЙ

Улаан армийн намын байгууллагуудад хувиа бодох үзлийн хандлага нь дор дурдсан янз бүрийн байдлаар илэрдэг. Үүнд:

1. Хариу авах үзэл. Зарим хүмүүс намын байгууллагын дотор байлдагч нөхөддөө шүүмжлэгдсэн бол намын байгууллагын гадуур түүнээс хариу

авах завшаан олохыг оролддог. Зодох хараах нь хариу авахын арга хэлбэрийн нэг мөн. Намын байгууллагын дотор ч хариу авахыг оролддог: «Чи энэ хурал дээр намайг шүүмжилсэн тул дараагийн хурал дээр би өө сэв эрээд чамаас хариу авна». Иймэрхүү хариу авах үзэл бол тэр бүхнээрээ хувиа бодох үзлийн үүднээс гардаг бөгөөд ангийнхаа эрх ашиг ба нийт намынхаа эрх ашгийг үл ойшоодог. Тэр нь дайсагнагч ангиудын эсрэг биш, харин эгнээнийхээ зарим хүмүүсийн эсрэг чиглэдэг юм. Энэ бол байгууллага ба түүний дайчин чадлыг сулруулах хор юм.

2. Жижиг бүлэглэлийн үзэл. Зарим хүмүүс жижиг бүлгийнхээ ашиг сонирхолд анхаарахаас биш, нийт олны эрх ашигт анхаарахгүй байдаг. Өнгөн дээрээ хувийн төлөө зүтгэх биш боловч, үнэн хэрэгтээ хувиа бо-

дох туйлын явцуу үзлийг агуулж байдаг. Жижиг бүлэглэлийн үзэл нь мөн ялзруулах, сарниулах нөлөө үзүүлдэг юм. Улаан армид жижиг бүлэглэлийн явдал аль хэзээнээс их дэлгэрч ирсэн бөгөөд шүүмжилсний үрээр одоогийн байдал баахан сайжирсан юм. Гэвч үлдэгдэл нь бас ч оршиж байгаа учраас түүнийг арилгахад мөн л хүч чармайлт гаргах хэрэгтэй.

3. Хөлслөгдөгч үзэл санаа. Нам, Улаан арми бол хувьсгалын зорилтуудыг биелүүлэх багаж зэвсэг мөн бөгөөд өөрийн бие нь тэдгээрийн бүрэлдэхүүний нэг болно гэдгийг ийм үзэл санаатай хүмүүс ойлгохгүй байна. Өөрийгөө хувьсгалд эзэн болохыг ойлгоогүй, харин хувьсгалын төлөө биш, зөвхөн даргынхаа төлөө л хариуцаж байна гэж тэд үзэж байна. Хувьсгалд хөлслөгдөгч энэхүү идэвх-

гүй үзэл санаа бол мөн ч хувиа бодох үзлийн илрэл юм. Хувьсгалд хөлслөгдөгч энэхүү үзэл санаанаас болж хувьсгалд бүх хүчээ үг дуугүй зориулдаг идэвхтэн тийм олон гарсангүй юм. Хөлслөгдөгч үзэл санааг арилгахгүй бол идэвхтэн олшрох боломцоогүй болж, хувьсгалын хүнд бэрх үүрэг цөөхөн хүний мөрөнд ямагт тавигдаж, тэмцэлд туйлын их ашиггүй болно.

4. Цэнгэх үзэл. Цэнгэлдэн жаргах байдлаар илэрч байгаа хувиа бодох үзэлтэй хүн Улаан армийн дотор цөөнгүй байна. Цэргийн ангиудыг том хотод орохыг тэд үргэлж хүсдэг. Тэд ажиллахын төлөө биш, харин цэнгэлдэн жаргахын төлөө том хотод орохыг эрмэлздэг юм. Тэд, аж амьдралын талаар хүчир бэрхшээлтэй байгаа улаан районуудад ажиллахад хамгийн дургүй байдаг.

5. Ажилдаа назгайран хойргоших нь. Зарим хүн ямар нэг хэрэг явдал санаандаа бага зэрэг нийцэхгүй бол назгайран хойргошиж ажил хийхгүй болчихдог юм. Түүний шалтгаан нь голдуу хүмүүжүүлэх ажлыг хангалтгүй явуулсанд оршино, гэвч тэр нь удирдагчдаас асуудлыг шийдвэрлэх, ажлыг хувиарлан даалгах буюу сахилга батын арга хэмжээг авч явуулах талаар зохисгүйдсэнд ч оршино.

6. Армиас салах үзэл санаа. Улаан армийн дотор армиас салаад орон нутагт шилжин ажиллахыг гуйсан ажилтан нарын тоо өдрөөс өдөрт олширсоор байна. Энэ нь тэр бүхнээрээ хувийн шалтгаанаас болсон биш, харин бас: а) Улаан армийн материаллаг аж байдал маш дорой; б) урт удаан хугацаагаар тэмцэж ирснээс болж ядран зүдэрсэн; в) удирдагчдаас асуудлыг шийдвэр-

лэх, ажлыг хувиарлан даалгах буюу сахилга батын арга хэмжээг авч явуулах талаар зохисгүйдсэн гэх зэргээс болсон юм.

Засаж залруулах арга нь гэвэл: голдуу үзэл санааны хувьд хувиа бодох үзлийг даван туулахаар хүмүүжүүлэх ажлыг хүчтэй болгоно. Үүнээс гадна асуудлыг шийдвэрлэх, ажлыг хувиарлан даалгах, сахилга батын арга хэмжээг авч явуулахад зохистой байвал зохино. Үүний зэрэгцээгээр Улаан армийн материаллаг аж байдлыг сайжруулахад чиглэсэн арга хэмжээ авч, цэргийн ангиудыг амруулан цэгцлэхээр бололцоо бүхнийг ашиглаж, улмаар материаллаг нөхцөл байдлыг сайжруулах хэрэгтэй. Нийгмийн уг сурвалжаас нь авч үзвэл, хувиа бодох үзэл бол жижиг хөрөнгөтний болон хөрөнгөтний үзэл суртлаас намын дотор туссан тусгал нь

юм. Хүмүүжүүлэх ажлыг явуулахад үүнийг тайлбарлаж өгөх нь чухал.

ТЭНҮҮЛ ДЭЭРЭМЧИЙН ҮЗЭЛ САНААНЫ ТУХАЙ

Улаан армийн дотор их олон тооны тэнүүлч этгээд байгаа бөгөөд улс даяар, ялангуяа өмнөд мужуудад өргөн олон тэнүүлч түмэн оршиж байгаа учраас Улаан армийн дотор тэнүүл дээрэмчийн улс төрийн үзэл санаа бий боллоо. Энэ үзэл санааны илрэл нь: 1) тулгуур баазуудыг байгуулан ард олны засгийг тогтоож, түүнчлэн үүгээр улс төрийн нөлөөгөө өргөтгөхөд шургуу ажиллахыг хүсэхгүй, харин партизаны нүүдлийн ажиллагаагаар улс төрийн нөлөөгөө өргөтгөхийг л эрмэлзэж байна; 2) Улаан армийг өргөтгөхөд орон нутгийн

Улаан гвардийн отрядыг ба Улаан армийн орон нутгийн цэргийг өргөтгөсний үндсэн дээр Улаан армийн байнгын цэргийг өргөтгөх замаар биш, харин «цэрэг татах ба морь худалдан авах», «бууж өгөгсөд ба бослого гаргагсдыг талдаа оруулах» замаар өргөтгөнө; 3) олон түмэнтэй хамтаар хүнд хэцүү тэмцлийг тэсвэртэй хийхийг хүсэхгүй, харин том хотод орж ханатлаа идэж уухыг л хүсдэг. Тэнүүл дээрэмчийн үзэл санааны эдгээр бүх илрэл нь Улаан армиас үүргээ гүйцэтгэхэд туйлын их саад болж байдаг учраас тэнүүл дээрэмчийн үзэл санааг арилгах явдал үнэхээр Улаан армийн намын байгууллагуудын доторхи үзэл суртлын тэмцлийн чухал зорилгуудын нэг болох юм. Түүхэнд байсан Хуан Чао, Ли Чуангийн маягийн тэнүүл дээрэм-

чийн тийм үзэл санаа одоогийн нөхцөл байдалд гаргаж үл болом зүйл болсныг ойлговол зохино.

Засаж залруулах арга нь гэвэл:

1. Хүмүүжүүлэх ажлыг хүчтэй болгож, зөв бус үзлүүдийг шүүмжлэн, тэнүүл дээрэмчийн үзлийг арилгана.

2. Улаан армийн одоо байгаа үндсэн бүрэлдэхүүний ба олзлогдогсдоос Улаан армид шинээр элсэн орсон хүмүүсийн дунд тэнүүл үзэл санааны эсрэг хүмүүжлийн ажлыг хүчтэй болгоно.

3. Тэмцлийн туршлагатай ажилчин тариачин идэвхтэн нарыг Улаан армийн эгнээнд татан оруулаад Улаан армийн бүрэлдэхүүнийг өөрчилнө.

4. Тэмцэж байгаа ажилчин тариачин олны дунд Улаан армийн шинэ ангиудыг зохион байгуулна.

ПУТЧИЗМИЙН ҮЛДЭГДЛИЙН ТУХАЙ

Улаан армийн намын байгууллагуудын дотор путчизмийн эсрэг тэмцэл хийж байсан боловч хангалттай хийж чадаагүй. Ийм учраас Улаан армийн дотор путчист үзэл санааны үлдэгдэл бас ч оршиж байна. Түүний илрэл нь гэвэл: 1) субъектив, объектив нөхцөлийг харгалзахгүй, сохроор ажилладаг; 2) хотын талаархи бодлогыг бүрэн төгс биш, эрс шийдэмгий биш хэрэгжүүлдэг; 3) цэргийн сахилга бат нь сул, ялангуяа байлдаанд ялагдсан үед ийм байдаг; 4) цэргийн зарим ангиудаас байшинг шатаах явдал бас гардаг; 5) эрүүдэх явдал ба оргосон цэргийг буудан алах явдал нь мөн ч путчизмийн шинж чанартай юм. Нийгмийн уг сурвалжаас нь авч үзвэл, путчизм бол люмпен-пролетари

нарын болон жижиг хөрөнгөтний үзэл суртлын нийлбэр мөн.

Засаж залруулах арга нь гэвэл:

1. Үзэл суртлын талаар путчизмийг арилгана.

2. Зохих дүрэм тогтоол, улс төрийн бодлогыг хэрэгжүүлэх замаар путчист явдлыг устгана.

ЛИБЕРАЛИЗМЫГ ЭСЭРГҮҮЦЭХ НЬ

(1937 оны 9 дүгээр сарын 7)

Бид үзэл суртлын идэвхтэй тэмцэл хийх явдлыг баримталдаг. Учир нь тэр бол намын болон хувьсгалт байгууллагуудын дотоодын нягтралыг хангаж, тэмцэлд нь тус үзүүлэх зэвсэг мөн. Энэхүү зэвсгийг коммунист намын гишүүн ба хувьсгалч хүн нэг бүр хэрэглэх ёстой.

Гэтэл либерализм нь үзэл суртлын тэмцлийг хэрэгсэхгүй болгож зарчимгүй эв найрамдлыг баримталж байна. Түүний уршгаар ялзармал, бэртэгчин

стиль үүсч, улмаар намын болон хувьсгалт байгууллагуудын зарим хэсэг, зарим хүн улс төрийн талаар ялзран доройтоход хүрдэг юм.

Либерализм янз бүрийн хэлбэрээр илэрдэг. Үүнд:

1. Буруугий нь мэдэж байгаа боловч хуучин танил, нэг нутгийнхан, нэг сургуулийнхан, дотнын найз, хайрт хүн, удаан жил хамт ажилласан хүн буюу удаан жил гар дор ажилласан хүн болохоор тэдэнтэй зарчимт маргаан хийхгүй, зөнд нь орхисноороо эе эвтэй, элэгсэг дотно болохыг оролддог; эсхүл халт мөлт хэлж өнгөрөөгөөд асуудлыг тууштай шийдвэрлэхгүй, эв найртай байхыг л боддог. Үүний улмаас хамт олонд ч, өөрт нь ч хохирол учруулна.

2. Хариуцлагагүйгээр далдуур шүүмжилдэг, байгууллагадаа санал зөвлөлгөө идэвхтэйгээр гаргахгүй

байдаг; нүүр дээр нь хэлэхгүй, ард нь дураараа ярьдаг; хурал дээр дуугүй суугаад хурлын дараа хамаагүй чалчдаг. Хамтач амьдралын зарчмыг огт хайхрахгүй, харин зөвхөн дураараа явахыг л боддог.

3. Ажил хэргийг биедээ хамаагүй гээд аль болохоор биеэсээ холдуулдаг; буруугий нь мэдсээр байгаа боловч бага хэлбэл дээр гэж боддог; хэвээ сахиж хэргээс зайлахыг мэргэнд үздэг.

4. Тушаал заавры г дагахгүй, хувийнхаа саналыг юунаас ч чухал гэж үздэг; байгууллагаасаа хайр халамжийг л шаардаад харин байгууллагынхаа сахилга батыг дагахгүй байдаг юм.

5. Нэгдэл нягтралын төлөө, дэвшлийн төлөө, ажлаа сайжруулахын төлөө буруу үзэлтэй тэмцэж маргалдахын оронд хувийн дайралт хийж,

зориуд зөрөлдөн, хувийн хорслоо тоочиж, хариу авдаг.

6. Буруу санал шүүмжлэлийг сонссон боловч маргаан хийхгүй; тэр ч байтугай хувьсгалын эсэргүү үг яриаг сонссон ч гэсэн мэдүүлэхгүй, юу ч болсонгүй мэт санаа амар суудаг.

7. Олон түмэнтэй харилцахад сурталл нэвтрүүлэг, ухуулгыг явуулахгүй, яриа хийж өгөхгүй, судалгаа хийхгүй, асууж лавлахгүй, тэдний амин чухал эрх ашгийг санаандаа авч бодохгүй, тэдэнд хайхрахгүйгээр хандаж, өөрийгөө коммунист намын гишүүн болохыг мартаад энгийн ардтай адил гэж үздэг.

8. Олон түмний эрх ашигт хор хохирол учруулах үйл ажиллагааг үзээд эгдүүцэхгүй, ятгахгүй, зогсоохгүй, тайлбарлахгүй, харин түүнийг зөнд нь тавьдаг.

9. Ажилдаа нягт нямбайгаар хандахгүй, тодорхой төлөвлөгөөгүй, тодорхой зүг чиггүй, хааш яаш хандаж, ингэж тэгж аргацаан алба хашиж ам хаагаад өдрийг өнгөрөөдөг.

10. Өөрийгөө хувьсгалд гавьяатай гээд удаан ажилласандаа ихэрхэн, том ажлыг хийж чадахгүй байтлаа жижиг ажлыг хийх дургүй, ажилдаа хааш яаш хандан, сурлагадаа цалгар назгай байдаг.

11. Буруу болсноо мэдсээр байгаад залруулахыг хүсэхгүй, өөрөө өөртөө либерализмаар ханддаг.

Үүнээс өөр бас нилээд жишээ гаргаж болох юм. Гол нь энэ арван нэгэн зүйл болно.

Эдгээр бүхэн нь либерализмын илрэл мөн.

Хувьсгалчдын хамт олны доторхи либерализм бол тун хортой юм. Тэр нь нэгдэл нягтралыг задруулж, ба-

рилдлагаа холбоог сулруулж, ажлын идэвхийг алдагдуулж, санал зөрөлдөөнийг үүсгэх ялзруулагч хор мөн. Либерализм хувьсгалт эгнээний бат чанга зохион байгуулалт ба сахилга батыг алдагдуулан, улс төрийн бодлогыг тууштай хэрэгжүүлэх бололцоогүй болгож, намын байгууллагыг намын удирдаж байгаа олон түмнээс хөндийрүүлэх болно. Энэ бол хүнд сүрхий муу хандлага мөн.

Либерализмын уг сурвалж нь жижиг хөрөнгөтний амины ашгийг бодох явдалд, тухайлбал хувийн ашгийг нэгдүгээр байранд, хувьсгалын ашгийг хоёрдугаар байранд тавих явдалд оршино. Үүнээс болж үзэл суртал, улс төр ба зохион байгуулалтын талаар либерализм үүсэн гардаг юм.

Либералууд марксизмын зарчмуудыг хийсвэр догмаар үздэг. Тэд марксизмыг зөвшөөрөн хүлээсэн бо-

ловч түүнийг амьдралд хэрэгжүүлэх санаагүй буюу эсхүл түүнийг гүйцэд хэрэгжүүлэх санаагүй байдаг; тэд өөрсдийн либерализмыг марксизмаар солих хүсэлгүй. Эдгээр хүмүүст марксизм ч бий, либерализм ч бий, аман дээр нь марксизм, ажил дээр нь либерализм; бусдад марксизмаар, биедээ либерализмаар ханддаг. Энэ хоёр зүйлийн аль алин ч бүрдээд тус бүрд хэрэглэгддэг. Хэсэг хүмүүсийн сэтгэхүйн арга ийм байна.

Либерализм нь оппортунизмын нэг илрэл мөн бөгөөд марксизмд үндсээрээ харшилдаг юм. Либерализм бол идэвхгүй зүйл бөгөөд бодит байдал дээр дайсанд тусалдаг. Ийм учраас бидний дунд либерализм оршиж байхыг дайсан хүсэж байдаг. Либерализм ийм чанартай болохоор хувьсгалт эгнээнд түүний байрыг байлгах ёсгүй.

Бид марксизмын идэвхтэй зориг санаагаар либерализмын идэвхгүй байдлыг ялан давах ёстой. Коммунист намын гишүүн уужим цагаан сэтгэлтэй, үнэнч шудрага, идэвхтэй байж хувьсгалын эрх ашгийг амь наснаасаа эрхэмд үзэж хувийнхаа ашиг тусыг хувьсгалын эрх ашигт захирагдуулах ёстой; тэр нь хэзээ хаана ч гэсэн зөв зарчмыг хатуу баримталж, зөв бус үзэл бодол, үйл ажиллагаа бүхний эсрэг цуцалтгүй тэмцэж, ингэснээрээ намын хамтач амьдралыг бататгаж, нам ба олон түмний хоорондохь холбоог бэхжүүлэх хэрэгтэй; тэр нь амиа бодохоос нам ба олон түмний төлөө, бусдын төлөө илүү санаа тавивал зохино. Зөвхөн ийм хүн л коммунист намын гишүүн гэж нэрлэгдэж болох юм.

Коммунист намын чин үнэнч, цайлган санаатай, идэвхтэй, шулуун шуд-

рага гишүүн бүхэн нэгдэн нягтарч хэсэг хүмүүсийн либерал хандлагыг эсэргүүцэж, тэднийг зөв талд зогсдог болгох хэрэгтэй. Энэ бол үзэл суртлын фронт дээрх бидний зорилтуудын нэг нь мөн.

毛主席的五篇著作
*
外文出版社出版（北京）
1972年版
编号：（蒙）1050—1466
00023
1—M—911Pk